

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХҮРЭЭНД 2019 ОНД АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ ТОГТООМЖ АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ


2020.01.16

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүн	Биелэлт
Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх, ёс зүйг дээшлүүлэх			
1	Нийтийн албанд нийтийн томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд нээлттэй болгох, байгууллагын вэб сайтад байршуулах	АТГ-аас ирүүлсэн дүгнэлтийг тухай бүр байгууллагын сайтад байршуулсан байх	2019 онд Хувийн ашиг сонирхлын урьдчилан мэдүүлэг /ХАСУМ/-ийг хянуулахаар албан тушаалтан томилогдоогүй байна. 2018 онд АТГ-ын дүн шинжилгээний хэлтэст хянуулахаар 3 албан тушаалтны тодорхойлолтыг хүргүүлж, хянуулсан албан тоотыг байгууллагын Or.mohs.gov.mn сайтад байршуулсан.
2	Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмын дагуу авах, бүртгэх, хянан шалгах.	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, мэдэгдлийн бүртгэл, хяналт сайжирсан байна.	2019 онд Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, бүртгэж хянаж хуулийн хугацаанд 5 албан хаагчдын материалыг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хүлээн авсан тухай бүртгэлийг дэвтэрт цаг тухайд нь хөтлөн ажиллаж, АТГ-ын ЭБАТ-ын эрхээр тайлангаа шивж хуулийн хугацаанд төв ЭБАТ-д хүргүүлэн ажилласан. Эрүүл мэндийн газрын 5 төрийн жинхэнэ албан хаагчийн төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийг аймгийн Засаг даргын захирамжийн дагуу нэмэгдүүлсэн. Үүнд: дөтгөөр зэрэг, ахлах түшмэл - 1, тэргүүн зэрэг, дэс түшмэл-1, гутгаар зэрэг, дэс түшмэл-1, дөтгөөр зэрэг дэс түшмэл-2 бөгөөд тус тус төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдлийг олгож ажилласан байна.
3	Төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг байгууллагын вэб сайтад байршуулах.	Нөөцийн жагсаалт, бүртгэл ил тод нээлттэй байршуулж хэвшсэн байх	Тус газраас 2019 онд төрийн захиргааны 7 албан хаагч чөлөөлөгдөж, чөлөөгдсөн тухай тушаалын хувийг тухай бүр нь Орхон аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд албан бичгээр хүргэж ажилласан. Чөлөөлөгдсөн шалтгаан нь: өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 1, харьяалах дээд шатны байгууллага болон бусад байгууллагад шилжин ажиллаж байгаа 2, хүүхэд асрах чөлөө авсан 1, гадаад улс руу гэр бүлийн хамт шилжин амьдрах болж өөрийн хүсэлтээр 1, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж чөлөөлөгдсөн 2 албан хаагч байна. Төрийн захиргааны 12 албан хаагчийн сул орон тооны мэдээллийн зарыг Орхон аймаг дахь төрийн албаны салбар зөвлөл, Эрүүл мэндийн яамны цахим сайтад байршуулахаар 4, 8 дугаар саруудад шинэчлэн хүргүүлсэн. Байгууллагын 2020 онд батлагдсан бүтэц, орон тоогоор ажиллахад дутагдалтай байгаа төрийн захиргааны албан тушаалтны сул орон тооны мэдээллийг www.or.mohs.gov.mn вэб хуудсанд байршуулахаар бэлтгэл ажил хийгдэж байна.
4	Төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг холбогдох журмын дагуу албан тушаал бүрээр боловсруулан баталж мөрдүүлэх.	Албан тушаал бүрээр шинэчлэн боловсруулан баталсан байх	Эрүүл мэндийн газар аймгийн Засаг даргын 2019 оны “Эрүүл мэндийн газрын бүтэц, орон тоог батлах тухай” А/413 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган төрийн захиргааны 24 албан хаагч, төрийн үйлчилгээний 12 албан хаагч, нийт 36 орон тоотой ажилласан.

			<p>Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын Б/04 дүгээр тушаалаар “Ажлын хэсэг” байгуулж, Эрүүл мэндийн газрын төрийн захиргааны албан хаагчдын ажлын байранд чиг үүргийн шинжилгээ хийж 23 төрийн захиргааны албан хаагчийн ажлын байранд хууль тогтоомжоор заасан үндсэн болон дэд, туслах чиг үүргийг тодорхойлж, ажлын байрны шинжилгээг хийсэн. Ажлын байрны шинжилгээн дээр үндэслэн албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 37 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, тус газрын төрийн захиргааны 23 албан тушаалтны тодорхойлолтыг “Зөвшөөрөл олгох тухай” 149 дүгээр тогтоолоор ТЗ-5 ангилал зэрэглэлээр батлах зөвшөөрөл олгосон. Уг тогтоолын дагуу Эрүүл мэндийн газрын даргын 2019 оны А/76 дугаар тушаалаар Эрүүл мэндийн газрын төрийн захиргааны 23 албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг албан тушаал бүрээр баталж, байгууллагын албан хаагчдад танилцуулан тушаалын хэрэгжилтийг ханган ажиллалаа. Мөн тус газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 63 дугаар тогтоолын дагуу аймгийн Засаг дарга 2019 оны “Албан тушаалын тодорхойлолт батлах тухай” А/704 дүгээр захирамжийг баталж ирүүлсэнийг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p>
5	<p>Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийг шинээр байгуулж, Зөвлөлийн ажиллах журмыг баталж мөрдүүлэх</p>	<p>ЗГ-ын 2019 оны 33-р тогтоолоор батлагдсан журмын дагуу ёс зүйн зөвлөлийг шинээр байгуулж, ажиллах журмыг баталж мөрдүүлсэн байх.</p>	<p>Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөвлөлийг албан хаагчдаас санал авч, Эрүүл мэндийн газрын дарга болон БОЭТ-ийн захирлын тушаалаар байгуулан, зөвлөлийн ажиллах журмыг батлан мөрдүүлж ажиллалаа. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулж, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, төрийн албан хаагчийн эрхэмлэх есөн зүйлийг сурталчлан таниулах зорилгоор АХА тэмцээн, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн нэрэмжит өдөр, алба хаагч нарыг оролцуулсан шторкыг хийж сурталчлан ажилласан. Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолоор баталсан дүрмийн дагуу нэмэлт өөрчлөлт оруулсан. Ёс зүй, харьцаа хандлагыг сайжруулах чиглэлээр “Төрийн албан хаагчийн үйлчилгээнд тавигдах шаардлага” /CS61-0020:2015/-ыг батлуулан хэрэгжүүлж, төрийн албан хаагчдын ажлын үр дүнг үнэлэхдээ 1 шалгуур болгон дүгнэсэн. Тайлант хугацаанд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, гомдол, санал болон захиргааны зөрчил, гэмт хэрэг гараагүй. Тайлант хугацаанд эрүүл мэндийн байгууллагын ажилтан болон эмчилгээ үйлчилгээтэй холбоотой талархал тогтмол өсч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад талархал 5,2 дахин өссөн үзүүлэлттэй байна.</p>

6	Төсвийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах.	Худалдан авах ажиллагаа зохих хууль, журмын дагуу явагдсан байна.	2019 онд Эрүүл мэндийн салбарт нийт 1 тэрбум 291,7 сая төгрөгийн тендерыг зарлан Улсын төсвийн хөрөнгөөр сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд жирэмснээс сэргийлэх эм, хэрэгсэл, эхийн амин дэм, 6-23 сартай хүүхдийн бичил тэжээлээр хангахаар 91,7 сая төгрөгийн тендер зарлан Эрүүл мэндийн газар дээр нээлттэй тендер зарлан “ЭМ ЭС АЙ СИ СИ”, Еврофарм ХХК шалгарч нийлүүлэлтийг 100 хувь хийсэн. Мөн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эмийн зардалд 1 тэрбум төгрөгийн 35 багц дээр нээлттэй тендер зарлан гүйцэтгэгч компаниуд шалгарч “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн дагуу 100 хувь нийлүүлэгдсэн. Сангийн сайдын 2018 онд батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын дагуу тайлант хугацаанд хийгдсэн худалдан авах ажиллагааны тайланг ЭМЯ болон орон нутгийн өмчийн газар тайлагнасан.
---	--	---	--


Хоёр. Соён гэгээрүүлэх ажлын хүрээнд

1	Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг ёс зүйн болон соён гэгээрүүлэхэд чиглэсэн шторк, мэдээ, мэдээллийг нийт ажилтан, албан хаагчдад тогтмол хүргэж хэвших.	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл хүргэгдсэн байна.	<p>2018 оны 06-р сарын 27-ны өдрийн 03 албан тоотоор Эрүүл мэндийн сайдын Албан даалгаварын хүрээнд Эрүүл мэндийн салбарын хэмжээнд авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд АТГ-аас богино хэмжээний теле зохиомж гарган ирүүлсэн байна.</p> <p>Уг богино хэмжээний теле зохиомжийг Эрүүл мэндийн салбарын хэмжээний удирдлагуудын өргөтгөсөн шуурхай хурал дээр зохиомжийг гарган холбогдох үүрэг даалгавар өгч ажилласан.</p> <p>Нийт 12 эрүүл мэндийн салбарын байгууллагууд өөрийн байрандаа мэдээллийн дэлгэцээр болон цахимаар тогтмол теле зохиомжийг өдөр бүр явуулж иргэдэд авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээллийг хүргэж ажиллаж байна.</p> <p>Эрүүл мэндийн газар /Нийгмийн эрүүл мэндийн төв/ теле зохиомжийг байршуулсан.</p>  <p>БОЭТ-ийн мэдээллийн дэлгэцээр богино хэмжээний теле зохиомжийг байршуулсан.</p>
---	--	---	---




Мөн Авлигатай тэмцэх газрын Нийтийн албан тушаалтны зүгээс гаргаж байгаа ашиг сонирхлын нийтлэг зөрчил, анхаарах асуудал, албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг шалгах үндэслэл, хариуцлагын төрөл, анхаарах асуудал, зөрчил дутагдлын талаар харандааны зураглалаар хийгдсэн 3 төрлийн шторк, сурталчилгаа /зохиомжит промо-г АТГ-ын www.iaac.mn цахим хуудсанд байршуулсныг татан авч Эрүүл мэндийн газрын цахим хуудас болон БОЭТ, Медипас, Жаргалант сумын ЭМТ, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн цахим хуудас, сурталчилгааны дэлгэцээр тогтмол явуулж нийт 30 удаагийн давтамжтайгаар явуулсан.








2019 онд Эрүүл мэндийн яам, Авлигатай тэмцэх газраас камтарч олон нийтэд чиглэсэн “Инээмсэглэл бидэнд урам” зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаа. Тус хөтөлбөрийн хүрээнд Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, эмнэлгийн мэргэжилтэн эрүүл мэндийн ажилтан, иргэдийн хооронд өөрэг зөв хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн “Инээмсэглэл Бидэнд Урам” зорилтот хөтөлбөрийн хүрээнд Эрүүл мэндийн газар 7 ажил тусган төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн биелэлт 95 кувьтай гарсан.

Эрүүл мэндийн газар дээр уг ажлыг сурталчилан анонсыг байршуулан, 5 ширгэх барнер хийлгүүлэн угтах үйлчилгээнд ашиглан иргэдээс санал, хүсэлт, сэтгэгдлийг хүлээн авч уг аяны хүрээнд 6 иргэнээс талархал, сэтгэлийн үгээ бичсэн байна.



			
2	<p>Байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт авлигын эсрэг хууль, тогтоомж, зөвлөмж, сайн туршлагыг байршуулах, сурталчилах.</p>	<p>Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлийн мэдээллээр хангагдсан байна.</p>	 <p>Байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт авлигын эсрэг хууль тогтоомж болон мэдээллийн самбарт байршуулж Эрүүл мэндийн яам болон Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийг эрүүл мэндийн салбарын хэмжээнд танилцуулан мөрдөж ажиллаж байна. БОЭТ цахим сүлжээ болон WWW.ORKHOMBOET.mn/ сайт, мэдээллийн самбар, дотоод сүлжээндээ тогтмол байршуулан ил тод нээлттэй байршуулан ажилласан.</p> 
3	<p>Авлигын эсрэг үйл ажиллагаа, "Авлигатай тэмцэх үндэсний</p>	<p>Төлөвлөгөөг гарган 12-р сард</p>	<p>2019 онд Эрүүл мэндийн салбарын хэмжээнд үндэсний хөтөлбөрийг</p>

	хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргаж, хагас болон бүтэн жилээр тайлагнах, төлөвлөгөө болон тайланг байгууллагын сайтад байршуулж мэдээлж байх.	сайтад байршуулсан байна.	хэрэгжүүлэхээр 12 ажил тусган төлөвлөгөөг гарган ЭМГ-ын даргаар батлуулан хэрэгжилтийг Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээр гүйцэтгэлийн үнэлгээ хийж 91 хувийн биелэлттэй гарсан. Төлөвлөгөө болон тайланг Or.mohs.gov.mn , WWW.ORKHOMBOET.mn/ сайтанд байршуулан ажилласан.
Гурав. Хяналт, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх ажлын хүрээнд			
1	Шударга, төсвийн ил тод, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлж, төрийн ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгах.	Төсвийн ил тод байдал хангагдаж, шилэн дансны хуулийн хэрэгжилт, сахилга хариуцлага дэг журам чангатгана.	<p>Төрийн албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, ёс зүйн хэм хэмжээг сахиулах зорилгоор:</p> <ul style="list-style-type: none"> - Аймгийн ЗДТГ, Төрийн албаны салбар зөвлөл, Удирдлагын академитай хамтран 8 удаагийн сургалт зохион байгуулж, эрүүл мэндийн салбараас давхардсан тоогоор 147 албан хаагч оролцон хууль дүрмийн талаарх мэдлэгээ дээшлүүлсэн. - Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн харилцаа, хандлагыг сайжруулах, ёс зүйн алдаанаас урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 28 сургалт зохион байгуулж, 1125 эрүүл мэндийн ажилтан хамрагдсан. - Удирдлагын академийн төрийн удирдлагаар мэргэшүүлэх 1 жилийн сургалтад Эрүүл мэндийн газрын 2 мэргэжилтэн, хүний нөөцийн мэргэшүүлэх богино хугацааны сургалтад 2 албан хаагч, төсөв санхүүгийн чиглэлээр 2 албан хаагчийг хамруулж, мэдлэг ур чадварыг дээшлүүлсэн. - Ёс зүй, харьцаа хандлагыг сайжруулах чиглэлээр "Төрийн албан хаагчийн үйлчилгээнд тавигдах шаардлага" /CS61-0020:2015/-ыг батлуулан хэрэгжүүлж, төрийн албан хаагчдын ажлын үр дүнг үнэлэхдээ 1 шалгуур болгон дүгнэн ажилласан. <p>Тайлант хугацаанд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, гомдол, санал гараагүй. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй харилцаа, хандлагыг сайжруулах чиглэлээр сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж ажилласнаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч, ажиллагсдын харьцаа, хандлагатай холбоотой талархал 5 дахин их өссөн.</p>
2	Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын үйл ажиллагааг идэвхжүүлэх, хяналт шалгалтын ажлыг төлөвлөх, дүнг мэдээлэх, илэрсэн зөрчилд хариуцлага тооцох, шалгалтын мөрөөр тодорхой арга хэмжээг авч ажиллах /дүгнэлт, зөвлөмж, шийдвэр г.м/	Хяналт, хариуцлагын тогтолцоо сайжирна.	Дотоод хяналтын баг байгуулах тухай "Эрүүл мэндийн газрын даргын А/29 дүгээр тушаалыг шинэчлэн дотоод хяналтын багийг 2 удаа хуралдуулан төлөвлөгөөг батлуулан ажилласан. Төлөвлөгөөний дагуу 9 хяналт, төлөвлөгөөт бус 3 хяналт хийгдэж, зөвлөмж мэдээллийг хүргүүлэн ажилласан. МУЗГ-ын 2017 оны 89-р тогтоол "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", ЭМС-ын 2017 оны 422-р тушаал "Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам батлах тухай", Аймгийн Засаг даргын 2017 оны А/621 дүгээр захирамж, ЭМГ-ын даргын 2017 оны А/74 дүгээр тушаалыг тус тус үндэслэн эрүүл

			<p>мэндийн байгууллагуудтай хийсэн хамтын ажиллагааны гэрээг хагас бүтэн жилээр дүгнэн, зөвлөмжийн хэрэгжилтэд явцын хяналт хийж, хяналтын дүнд үндэслэн дотоодын сургалтыг 4 удаа зохион байгуулсан. Үүний дүнд:</p> <ul style="list-style-type: none"> – Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн гүйцэтгэлийн гэрээний хэрэгжилт дунджаар 85,9% буюу “Хангалттай” дүгнэгдсэн. – Хувийн хэвшлийн ортой эмнэлгүүдтэй 2019 онд хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилт дунджаар 77,2%-тай <p>Эм ханган нийлүүлэх байгууллагатай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний биелэлт 94%-тай дүгнэгдсэн байна.</p>
3	<p>Эрүүл мэндийн салбарт Гадаадын зээл тусламж, төсөл хөтөлбөрөөр хийгдэж буй арга хэмжээ бүрийн гүйцэтгэлийн явц, тайланг нээлттэй ил тод болгох</p>	<p>Хөрөнгө оруулат, төсөл хөтөлбөрийн гүйцэтгэлийг тооцож байгууллагын вэб сайтанд байршуулах</p>	<p>Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр хэрэгжиж буй гадаадын зээл тусламж, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрөөр дараах чиглэлээр хэрэгжиж байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. <u>Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ/Сүрьеэгийн төсөл</u> 2018 оноос 2020 он хүртэл үргэлжлэн ажиллаж байна. 2019 оны байдлаар аймгийн хэмжээнд <u>Монголын Сүрьеэтэй тэмцэх нийгэмлэгийн 7 эрүүл мэндийн сайн дурын идэвхтэн ажиллаж байгаа ба 24 өвчтөний эмчилгээг гэрээр хянан эмийг өдөр бүр харж уулган, сайн дурын 5 идэвхтэн эрт илрүүлгийн асуумж судалгаа авч эмч, мэргэжилтнүүдийн ажилд дэмжлэг үзүүлэн ажилласан.</u> <u>Глобаль сангаас 2019 онд эмийн зардалд 50,0 сая төгрөг, буцалтгүй тусламж 438,0 мянган төгрөг, сайн дурын идэвхитний унааны зардалд 7,5 сая төгрөгийг санхүүжүүлэн ажилласан.</u> 2. Орхон аймгийн БОЭТ нь ЭМЯ, ЭМХТ, Жайка Японы ОУХАБ-ын “Монгол Улсын анхан болон хоёр дахь шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах” төсөлтэй хамтран хэрэгжүүлж буй “Ерөнхий мэргэшил судлал” үндсэн мэргэшлийн сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад 2018 онд Аймгийн Засаг Даргын Тамгийн газраас 40.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн, төгсөлтийн дараах сургалтын лекц, хичээлийн танхим суралцагч эмчид зориулсан эрэгтэй эмэгтэй амрах өрөө, хувцас солих өрөө, хоол хийх гал тогоо, усанд орох шүршүүрийг тус бүр тохижуулсанаар сургалт явуулах орчин нөхцөл бүрдсэн. ЭМЯ-ны дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2019 оны 10 дугаар тогтоолоор “ЕРӨНХИЙ МЭРГЭШИЛ СУДАЛ”-ын үндсэн мэргэшлийн сургалтыг Монгол улсад анх удаа орон нутагт Орхон аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвд явуулах боломжтой болж 2018-2019 оны хичээлийн жилд сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж, 4 суралцагч эмчийг элсүүлэн “Анхны төгсөгч”-ийг амжилттай төгсгөсөн. ЭМС-ын 2019 оны А/456, А/457 тоот тушаалаар 2 дахь жилийн сургалтад 5 суралцагч эмч элсэн суралцаж байна. БОЭТ-ийн захирлын тушаалаар томилогдсон “Төгсөлтийн дараах сургалтын

			<p>хяналтын зөвлөл” ажиллаж ерөнхий мэргэшил судлалын сургалтын журам, хөтөлбөр, төлөвлөгөө, хуваарийг хэлэлцэн батлаж, төгсөлтийн дараах сургалтын хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна. Сургалтад хэрэглэх материалуудыг ЖАЙКА, Японы Олон Улсын Эрүүл Мэнд Анагаах Ухааны Үндэсний Төвийн олон улмын эрүүл мэндийн хамтын ажиллагааны газрын хүүхдийн болон эх барих эмэгтэйчүүдийн эмч нар, GENEPRO байгууллагатай хамтран боловсруулж, ЭМЯ-ны харьяа салбар мэргэжлийн зөвлөлөөр тус тус батлуулан тойролтын гарын авлагыг боловсруулж сургалтад хэрэглэж байна. Эрүүл мэндийн сайдын А/121 дүгээр тушаалаар тушаалаар үндсэн мэргэшлээр суралцах резидент эмчийн тоог баталсан бөгөөд БОЭТ-д ерөнхий мэргэшил судлалын чиглэлээр 2019-2020 оны хичээлийн жилд 5 резидент эмч суралцаж байна.</p> <p>3. Зүрх судасны ба эх нярайн эрүүл мэнд, цахим эрүүл мэндийн өргөжилт MON005 Люксембургийн вант улсын төслөөр хэрэгжиж, www.cardiocenter.telemedicine.mn, campus medicus вэб сайтад зүрх судасны өвчтэй иргэдийг бүртгэснээр телемедицинээр 3-р эмнэлгийн зүрх судасны нарийн мэргэжлийн эмчээс зөвлөгөө авч тайлант хугацаанд 600 хүнд зүрхний ЭХО хийснээс 10 хүнд телемедицинээр 3-р эмнэлгийн зүрх судасны нарийн мэргэжлийн эмчээс зөвлөгөөг авч ажилласан.</p> <p>4. ЭМСХХ-5 төслийн хүрээнд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хог хаягдлын ариутгалын байрыг 208,3 сая, тоног төхөөрөмжид 266,0 сая, нийт 474,3 сая төгрөгийн санхүүжилт тус тус шийдвэрлэж, үйл ажиллагаа жигдрэн ажилласан.</p> <p>Дээрх төсөл хөтөлбөрүүдийн талаарх мэдээ мэдээллийг байгууллагын сайтанд байршуулж, Эрүүл мэндийн газрын фэйсбүүк хуудсанд байршуулан ажиллаа.</p>
4	Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг бүх хэлбэрээр авч, шийдвэрлэн, шийдвэрлэлтэд хяналт тавьж, мэдээлэх	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт бүрэн шийдвэрлэгдсэн байна .	Тайлант хугацаанд эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой 228 санал, хүсэлт, гомдол, талархал ирснээс хүсэлт 69, гомдол 33, талархал 126 байгаа бөгөөд хуулийн хугацаанд нь 100% шийдвэрлэн ажилласан. Аймгийн Засаг Даргын Тамгын газрын иргэдийн санал хүсэлт хүлээн авах 70353511 утсаар нийт авч хуулийн хугацаанд нь иргэдэд хүлээлт чирэгдэл үүсгэлгүйгээр шийдвэрлэсэн. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй харилцаа, хандлагыг сайжруулах чиглэлээр сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж ажилласнаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч, ажиллагсдын харьцаа, хандлагатай холбоотой талархал 5 дахин их өссөн байна. Иргэдээс ирүүлсэн санал, хүсэлт, гомдол, талархал, тэдгээрийн шийдвэрлэлтийн талаар байгууллагын болон салбарын

			<p>өргөтгөсөн шуурхайд 7 хоног бүр тогтмол танилцуулан ажилласан. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хяналт тавих үйл ажиллагаанд Хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтсээс 2 удаа дотоод хяналт хийж, зөвлөмж өгч ажилласан. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын тайлан мэдээг хуулийн дагуу хугацаанд нь ЭМЯ, АЗДТГ-т гаргаж хүргүүлсэн.</p>
5	<p>АТГ-аас ирүүлсэн зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, хэрэгжилтийг тайлагнах</p>	<p>Төлөвлөгөө хэрэгжилтийг ажилласан байх</p>	<p>гарган тооцож</p> <p>2018-2019 онд нийт 4 зөвлөмж ирж АТГ-аас 3, ЭМЯ-наас 1 зөвлөмж тус тус ирүүлж, ЭМЯ, АТГ хамтраад 2 удаагийн цахим хурал хийсэн. Уг зөвлөмжийн дагуу биелэлтийг гарган аймгийн Засаг Даргын Тамгын газарт албан тоотоор хүргүүлэн ажилласан. Биелэлтийг ЭМГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн мэргэжилтэнээр үнэлүүлж биелэлтийг тооцон байгууллагын вэб болон Or.mohs.gov.mn сайтанд байршуулан ажилласан.</p>

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ЭДИЙН ЗАСАГЧ Д.ОТГОНДЭЛГЭР